

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны дугаар
сарын.....-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар
хот

Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн
бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь
хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7, 47.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн 2026 онд нэмэгдэх хувь хэмжээ”-г 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарыг тогтоосон болон цаашид баримтлах аргачлалыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнэ нэмэгдэл хяналт, шалгалт тавьж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (П.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бигийн дарга (П.Очирбат), Сангийн яамны Төрийн нарийн бигийн дарга (М.Баярмагнай)-д тус тус үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭНГИЙН ҮНИЙН 2026 ОНД НЭМЭГДЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ

Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн суурь үнэ¹д үндэслэн бөөний үнийг нэмэгдүүлэх хэмжээг регрессив хуваарийн дагуу дараах байдлаар тогтооно:

- суурь нэгж үнэ 500 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 35 хувь;
- суурь нэгж үнэ 501-2000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 32 хувь;
- суурь нэгж үнэ 2001-10,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 29 хувь;
- суурь нэгж үнэ 10,001-50,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 26 хувь;
- суурь нэгж үнэ 50,001-200,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 23 хувь;
- суурь нэгж үнэ 200,001-1,000,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 20 хувь;
- суурь нэгж үнэ 1,000,001- 3,000,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 16 хувь;
- суурь нэгж үнэ 3,000,001 төгрөгөөс дээш үнэтэй эмэнд 12 хувь байна.

Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний үнэд үндэслэн жижиглэнгийн үнийг нэмэгдүүлэх хэмжээг регрессив хуваарийн дагуу дараах байдлаар тогтооно:

- бөөний нэгж үнэ 500 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 40 хувь;
- бөөний нэгж үнэ 501-2000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 37 хувь;
- бөөний нэгж үнэ 2001-10,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 34 хувь;
- бөөний нэгж үнэ 10,001-50,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 31 хувь;
- бөөний нэгж үнэ 50,001-200,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 28 хувь;
- бөөний нэгж үнэ 200,001-1,000,000 төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 25 хувь;
- бөөний нэгж үнэ 1,000,000- төгрөг хүртэлх үнэтэй эмэнд 21 хувь байна.
- бөөний нэгж үнэ 3,000,001 төгрөгөөс дээш үнэтэй эмэнд 17 хувь байна.

---oOo---

¹ 4.1.17."суурь үнэ" гэж үйлдвэрлэгчийн үнэ, тээвэр, даатгал, татвар, эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлтэй холбоотой зардлын нийлбэрийг;

НЭМЭГДЭХ ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООСОН БОЛОН ЦААШИД БАРИМТЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13²-т заасан жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарыг тогтооход энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Энэ аргачлалд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.2.1.“нэгж үнэ” гэж эмийн үнийг шахмал, капсул, ампул зэрэг хамгийн бага хэмжих нэгжийн үнэ;

1.2.2.“бөөний үнэ” гэж эм ханган нийлүүлэх байгууллагаас эрүүл мэндийн байгууллага, эмийн сан болон бусад эм ханган нийлүүлэх байгууллагад борлуулах эмийн үнэ;

1.2.3.“бөөний үнийн нэмэгдэх хэмжээний регрессив хуваарь” гэж эмийн суурь үнийн дүнгээс хамааран хувиар илэрхийлсэн бөөний үнийн нэмэгдэх хэмжээ;

1.2.4.“жижиглэнгийн үнэ” гэж эмийн сангаас иргэдэд борлуулах эмийн үнэ;

1.2.5.“жижиглэнгийн үнийн нэмэгдэх хэмжээний регрессив хуваарь” гэж эмийн бөөний үнийн дүнгээс хамааран хувиар илэрхийлсэн жижиглэнгийн үнийн нэмэгдэх хэмжээ.

Хоёр. Нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарыг тогтоох аргачлал

2.1.Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хэмжээг тогтоох нь дараах үе шатаас бүрдэнэ:

2.1.1.эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар импортын болон үндэсний үйлдвэрийн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн суурь үнийн мэдээний санг олон улсын нэршил, худалдааны нэр, тун хэмжээ, эмийн хэлбэр, савлалтын хэмжээ, бүртгэлийн дугаар, стандарт код, цувралын дугаар, үйлдвэрлэгч, гарал үүслийн улс тус бүрээр үүсгэнэ.

2.1.2.зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаар тогтоохдоо эм, эмнэлгийн хэрэгслийн чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын санал, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн татварын тайланд тайлагнасан борлуулалтын орлого болон зардлын хэмжээг үндэслэл болгоно.

² 4.1.13.“зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт” гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн тэргүүнд хэрэглэхээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан эм, эмнэлгийн хэрэгслийн нэрсийг;

2.1.3.эм, эмнэлгийн хэрэгслийн чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагаас жил бүрийн 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор саналыг авна.

2.1.4.Татварын ерөнхий газраас эм хангамжийн аж ахуй нэгжүүдийн татварын тайлангийн холбогдох мэдээллийг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор эм, Эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар авна.

2.1.5.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн үнэд нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарын саналаа жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.1.6. эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага саналыг үндэслэн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүд хамтран жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан батална.

2.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар тухайн оны зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн мэдээний санг олон улсын нэршил, худалдааны нэр, тун хэмжээ, эмийн хэлбэр, савлалтын хэмжээ, бүртгэлийн дугаар, стандарт код, үйлдвэрлэгч, улс тус бүрээр үүсгэнэ.

---oOo---